Хэрэгжих арга зүй. Анхан шатны сургалтанд бол эл лабораторийг хөдөлгөөнт үзүүлэн байдлаар ашиглаж болно. Ахлах ангид сурагчид физик үзэгдэл, хуулийг “нээх” зорилго тавьж тооцоо-дүрслэлт туршилт үйлдээд хэмжилтийн дүнг “KAMTASIA” програмаар хөдөлгөөнт мэдээлэлд хувиргана. Дараа нь туршилтын эл ший-зураг баримтыг тойруулан ухааныг уралдуулан ном хаялцах замаар асуудлын шийд рүү хамтаар тэмүүлнэ. Ургуулан сэдэж сэтгэх амин үйлийг өрнүүлэн мэтгэсээр шийдэлд хүрээд сурагчид тулгуур хуулийг өөрснөө “нээгээд”, математик томъёог гаргана. Тооцоо-дүрслэлт туршилтыг үйлдэх, утга тайллыг хийхэд багш эрдмийн удирдагчийн өндөрлөгт байж сурагчдыг “хол” төөрүүлэхгүй чиглүүлэхийг чанд эрхэмлэнэ.

Түлхүүр үгс: мэдээллийн технологи, загвар лаборатори, компьютер график, физик сургалт, физик зарчим.

ФИЗИК СУРГАЛТ

Эл лабораторийн гоц онцлог бол суралцагсад тооцоо-дүрслэлт туршилт үйлдээд баримтыг тойруулан ном хаялцсаар тулгуур хуулиудыг Кулон, Фарадей, Ньютон, Максвеллийн ... адилаар өөрснөө нээх боломж бүрдүүлж байгаад оршино.

Мэдээлэл харилцааны технологит суурилсан бичил лабораторийг нэвтрүүлснээр физик сургалтын чанарыг цаашид сайжруулж, сурагчидад сэтгэлгээний дадал олгох чухал хэрэглүүр бий болно. Үүнийг дэлхий нийтийн туршлага харуулж байна.

Физик сургалт дахь мэдээлэл харилцааны технологи нь юуны өмнө физикийн тулгуур туршлага, үзэгдлийн компьютер загвар болон онолын ойлголтыг компьютертэй “ном хаялцах” байдлаар турших, тооцоолох, сэтгэж хууль жам, зүй тогтлыг суралцагчдаар өөрсдөөр нь “нээлгэхэд” шууд чиглэж байна.

Туршилт тооцооноос ургуулан сэтгэж шийдэхүй.

Үзэгдэл юмсын хувирлын өрнөх зүй жамыг сурагчдаар яаж нээлгэх арга замыг тоймловол:

Нээдүгээрт: Загвар лабораторийг ашиглан хичээл заах нь үлгэр, домог мэт сонсгож, томъёог тулган заадаг байдлаас ангижирч, суралцагсад тухайн үзэгдлийн мөн чанарыг нь ухан ойлгож, хууль дүрэм, томъёог өөрсдөө нээн илрүүлнэ..

Хоёрдугаарт: Тооцоо-дүрслэлт туршилт болон тоон баримтыг тойруулан ном хаялцаж хуулийг нээх шийдэлд хүрэх юм.

Гуравдугаарт: Өмнөх үйлдлийг хийснээр суралцагчид физик томъёоллыг өөрсдөө гаргана.

Дөрөвдүгээрт: Багш бол мэдээллийг дамжуулагч, сонсгогч биш эрдэм шинжилгээний удирдагч байна.

Сурагчдыг хөгжүүлэх, хүмүүжүүлэх ач тус.


Энэхүү лабораторийг сургалтанд ашигласнаар сурагчдын төлөвшил, хөгжилд чухал ач тустай болно. Үүнд:

1. Сурагчдын физик сэтгэлгээ, сэтгэн бодох чадварыг хөгжүүлнэ.


* Electronic address: enkhsetseg@mul.s.edu.mn

2. Хэмжилт, тооцооноос ургуулан сэтгэж, асуудлыг шийдвэрлэх арга барилыг эзэмшинэ.
3. Хамтаараа ном хаялцан асуудлын шийдэлд хүрэх чадвар эзэмшинэ.
4. Физикийн хичээлээр сурагчдыг нийгэмшүүлж хамтран ажиллах, үг дуулах төлөвшил олгоно.

Бүтээсэн загвар лаборатори




Зураг-1. Ньютоны 2-р хуулийг нээн илрүүлэх загвар лаборатори.




Зураг-2. Термодинамикийн 2-р хуулийг судлах загвар лаборатори.



Зураг 3. Кирхгофын 2-р дүрэмийг судлах 3D загвар.



Зураг-4. Хоёр цэнэгийн цахилгаан орныг судлах загвар лабораторийн ажиллах талбар



Зураг-5. Брюстеровын хуулийг судлах загвар лаборатори, түүний ажиллах талбар.

Тооцоо-дүрслэлт туршилтаар физик зүй тогтлыг илрүүлэх зарчим

Жишээ-1: Ажил, потенциалын ялгаварыг тодорхойлох физик зарчим

Хэмжилт-1. Потенциалын радиусын дагуух буюу цэнэгийн орон дахь хамаарлыг хэмжих


№	$q(\text{нКл})$	$\phi(\text{В})$	$r(\text{м})$
1	1.6	20.28	0.72
2	1.6	12.06	1.21
3	1.6	9.03	1.60

Шинжилгээ-1: $r_1 < r_2 < r_3$ байхад

$\phi_1 > \phi_2 > \phi_3$. Потенциал зайнаас урвуу

хамааралтай. $\phi \sim \frac{1}{r}$

Дүрслэл-1:



Зураг-6. Потенциал зайнаас хамаарсан график.

Хэмжилт-2: Тухайн цэг дээр хүчлэгийн хэмжээг тооцоолох

№	$q(\text{нКл})$	$F(\text{нН})$	$r(\text{м})$
1	1.6	27.61	0.72
2	1.6	10.01	1.21
3	1.6	5.54	1.60

Тооцоо - 2:


$$E = \frac{F}{q} = \frac{27.61 \text{ нН}}{1.6 \text{ нКл}} = \frac{27.61 \cdot 10^{-9} \text{ н}}{1.6 \cdot 10^{-9} \text{ Кл}} = 17.3 \text{ н / Кл}$$

$$F = \frac{k \cdot q}{r^2} = \frac{9 \cdot 10^9 \text{ н} \cdot \text{м} / \text{Кл}^2 \cdot 1 \cdot 10^{-9} \text{ Кл}}{(0.72 \text{ м})^2} = 17.3 \text{ н} \cdot \text{м} / \text{Кл}$$

$$E = F$$

1нКл цэнэгт үйлчлэх хүчний хэмжээг цахилгаан орны хүчлэг гэнэ.

Дүрслэл-2: Цэнэгийг зөөхөд хийсэн ажил замын хэлбэрээс хамаарахгүй.



Зураг-7. Цахилгаан оронд цэнэг зөөхөд хийсэн ажил нь замын хэлбэрээс хамаарахгүй.

Хэмжилт-3: Ажлыг тооцоолох.

№	$q(\text{нКл})$	$F(\text{нН})$	$r(\text{м})$
1	1.6	27.61	0.72
2	1.6	10.01	1.21
3	1.6	5.54	1.60

Тооцоо: Төгсгөлгүй алсаас төвийн түлхэх хүчний эсрэг 1нКл цэнэгийг зөөхөд хийсэн ажлыг тооцоолох: $F \cdot S = A$

$$A_1 = 20.28 \text{ н} \cdot \text{м}, \quad A_2 = 12.06 \text{ н} \cdot \text{м},$$

$$A_3 = 9.03 \text{ н} \cdot \text{м}$$

Шинжилгээ-2: Дээрх хүснэгтээс харвал: $\varphi = A$.

№	$q(\text{нКл})$	$\varphi(\text{В})$	$A(\text{н} \cdot \text{м})$
1	1.0	20.28	20.28
2	1.0	12.06	12.06
3	1.0	9.03	9.03

Потенциал нь төгсгөлгүй алсаас 1 нКл эерэг цэнэгийг зөөхөд хийсэн ажилтай тэнцүү:

$$\varphi = \frac{A}{q}$$

Цэнэгийг зөөхөд хийсэн ажил нь:

$$A = q \cdot \Delta \varphi$$

Жишээ-2: Хугарлын хуулийг нээн илрүүлэх зарчим

Хэмжилт-1:

Хүснэгт-1

1-р орчны материал	1-р орчны хугарлын илтгэгч (n_1)	2-р орчны материал	2-р орчны хугарлын илтгэгч (n_2)	Тусгалын өнцөг (φ)	Хугарлын өнцөг (ψ)
Хөнгөн цагаан	1.39	Ус	1.33	36.87	38.8338
		Мөнгө	1.35		38.1539
		Мөс	1.473		34.4855
		Шил	1.55		32.5526

Шинжилгээ-1: Хэмжилтээс харвал $n_2 \sim \frac{1}{\sin \psi}$

урвуу хамааралтай байна.

Хэмжилт-2:

Хүснэгт-2

1-р орчны материал	1-р орчны хугарлын илтгэгч (n_1)	2-р орчны материал	2-р орчны хугарлын илтгэгч (n_2)	Тусгалын өнцөг (φ)	Хугарлын өнцөг (ψ)
Ус	1.33	Мөнгө	1.35	45.03	044.1867
Хөнгөн цагаан	1.39				46.7551
Мөс	1.473				50.5259
Шил	1.55				54.3158

Шинжилгээ-2: Хэмжилтээс харвал $n_1 \sim \sin \psi$ хамааралтай байна.

Хэмжилт-3:

Хүснэгт-3

1-р орчны материал	1-р орчны хугарлын илтгэгч (n_1)	2-р орчны материал	2-р орчны хугарлын илтгэгч (n_2)	Тусгалын өнцөг (φ)	Хугарлын өнцөг (ψ)
Мөс	1.473	Шил	1.55	27	25.5589
				39.59	37.2746

				46.56	43.6328
				55.07	51.1821

Шинжилгээ-3: Хэмжилтээс харвал
 $\sin \varphi \sim \sin \psi$ хамааралтай байна.

Шинжилгээг нэгтгэн дүгнэвэл:

$$n_2 \sim \frac{1}{\sin \psi} \quad n_1 \sim \sin \psi \quad \sin \varphi \sim \sin \psi$$

$$\text{Эндээс:} \quad \frac{n_1 \sin \varphi}{n_2} \sim \sin \psi \quad \frac{n_1}{n_2} \sim \frac{\sin \psi}{\sin \varphi}$$

Пропорционалийн коэффициент оруулбал:

$$\frac{n_1}{n_2} = k \frac{\sin \psi}{\sin \varphi} \quad k = \frac{n_1 \sin \varphi}{n_2 \sin \psi} \quad \bar{k} = 1$$

$$\frac{n_1}{n_2} = \frac{\sin \varphi}{\sin \psi} \quad - \text{Хугарлын хууль}$$

ДҮГНЭЛТ

1. Энэхүү физикийн загвар програмуудыг бүтээснээр туршилтын техникт бааз, лаборторгүй сургуулиудад физик туршилтыг хийх боломж бий болно.
2. Загвар лаборторийг ашиглан хичээл заах нь үлгэр, домог мэт сонсгож, томъёог тулган заадаг байдлаас ангижирч, суралцагсад тухайн үзэгдлийг мөн чанарыг нь ухан ойлгож, хууль дүрэм, томъёог өөрсдөө физик зүй тогтлыг нээн илрүүлдэг сургалтын шинэ аргыг бий болгоно.
3. Бид энэхүү физик үзэгдлийн загвар програмуудыг хийснээр загварчлалын, ялангуяа физик загварчлалын програмуудыг боловсруулах баялаг туршлагыг хуримтлууллаа.
4. Бид цаашид олж авсан мэдлэг, туршлагынхаа үндсэн дээр химийн, биологийн гэх мэт бусад үзэгдэл хувирлын загвар програмуудыг бүтээх боломжтой гэж үзэж байгаа.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- [1] П.Энхцэцэг, О.Лхагва, Т.Уламбаяр, Б.Алтанхүү “Физикийн 3D загвар лаборторийн CD” 2017 он.
- [2] Enkhtsetseg Purevdagva, Lkhagva Oidov, Ulambayar Tortogtokh “Virtual laboratory for physics teaching” Management and education innovation (ICMEI 2012), Vol-37, May 5-6, 2012, Kuala Lumpur, Malaysia.
- [3] O.Lkhagva, Kh.Otgonmunkh, T.Ulambayar, Kh.Tsookhuu, L.Erdenetuya “Use of physics laboratory model pilot for physics and distance learning” 2005

- [4] Enkhtsetseg Purevdagva, Lkhagva Oidov, Ulambayar Tortogtokh “Innovation in numerical experiment for teaching of elementary physics” and “Innovation in numerical experiment for teaching of elementary physics” ICNS 2018 international conference on modern trends in natural sciences and advanced technologies in science education, August 20-23, 2018 Ulaanbaatar, Mongolia.

Дэлхийн нам температурын цацрагийн энергийг дулаанд хувирган ашиглах боломж

Ж.Далхсүрэн*

Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль, Хэрэглээний Шинжлэх Ухааны Сургууль

Манай дэлхийн гадарга орчимын температур нь нам температурт харгалзах учираас уг гадарга нь урт долгионт цацраг буюу 5 мкм – 100мкм хүртэл долгионы урттай цацрагийг гаргадаг. Богино болон урт долгионт цацрагуудаар тодорхой хэмжээний энерги зөөгддөг. Хийн атом,молекулууд цацрагийн энергийг өөртөө шингээх замаар түүнийг дулааны энергид хувиргадаг онцлогтой. Дэлхийн гадаргаас 6м – 15м гүнд түүний абсолют температур дунджаар 278K –289K байх ба ийм температурын үед түүнээс гарах дулааны цацрагуудын долгионы урт нь 4мкм –80мкм–ийн завсарт харгалзана. Харин энэ завсарын цацрагуудаас хамгийн их энергитэй цацрагийн спектрт харгалзах долгионы урт нь 9мкм– 12мкм –ийн завсарт байдаг. Гэтэл нүүрсхүчлийн хийн молекулууд 13мкм – 17мкм,усны молекулууд 5мкм – 8мкм ба 14мкм –50мкм, озоны молекулууд 8.5мкм – 10.3мкм ба 13мкм –14.5мкм долгионы урттай цацрагуудын энергийг 40%– 99% шингээх чадвартай юм. Иймд эдгээр хийнүүд дунджаар 278K –289K температурт байгаа дэлхийн гадаргаас гарч буй дулааны цацрагуудын нийт энергийн 70 орчим хувийг шингээж авах замаар цацрагийн энергийг дулааны энергид хувиргах боломжтой байна. Ийм учираас дээрхи хийнүүдийг ашиглан дэлхийн гадарга орчимын урт долгионт цацрагийн энергийг дулааны энергид хувирган ахуйн хэрэглээнд ашиглах боломж байна.

PACS numbers: 33.22Ea, 33.20Fb, 33.20N.

ОРШИЛ

Абсолют тэг температураас ялгаатай температурт байгаа ямарч бие өөрөөсөө дулааны буюу температурын цацраг гаргадаг. Энэхүү цацрагийн долгионы урт нь биеийн температураас хамаарч янз бүр байна. Температурын цацрагийг долгионы уртаас нь хамааруулан богино ба урт долгионт цацраг гэж ангилдаг. Нам температурт байгаа биеүүд урт долгионт цацраг гаргадаг. Манай дэлхийн гадарга орчимын температур нам температурт харгалзах учираас уг гадарга нь урт долгионт цацраг буюу 5 мкм – 100мкм хүртэл долгионы урттай цацрагийг гаргадаг. Богино болон урт долгионт цацрагууд нь өөртөө тодорхой хэмжээний энергийг зөөдөг. Цацрагийн энергийг бодисын атом,молекулууд өөртөө шингээх замаар дулааны энергид хувиргадаг.Өөрөөр хэлбэл цацрагийн энергийг шингээсний дүнд хийн молекулуудын атомын хувийн хэлбэлзлийн тоо хэмжээ буюу хувийн хэлбэлзлийн давтамж, далайц нь нэмэгдэнэ. Үүний дүнд хийн молекулуудын эмх цэгцгүй хөдөлгөөний хурд мөн кинетик энерги нь ихсэнэ. Ийм хэлбэрээр цацрагийн энергийг дулааны энергид хувиргадана. Урт долгионт цацрагуудыг маш сайн шингээдэг бодисуудыг

ашиглан дэлхийн гадарга орчимын урт долгионт цацрагийн энергийг дулааны энергид хувиргах боломжтой. Тухайлбал, усны молекулууд 5мкм – 8мкм ба 13мкм–50мкм, озоны молекулууд 8.5мкм – 10.3мкм ба 13мкм–14,5мкм, нүүрсхүчлийн хий молекулууд 13мкм – 17мкм долгионы урттай цацрагуудыг 60% – 98% шингээдэг онцлогтой. Ийм учираас эдгээр хийнүүдийг ашиглан дэлхийн гадарга орчимын урт долгионт цацрагийн энергийг дулааны энергид хувирган ахуйн хэрэглээнд ашиглах боломжтой юм. Дэлхийн гадаргаас 6м – 15м гүнд түүний абсолют температур дунджаар 278K –289K байх ба ийм температурын үед түүнээс гарах дулааны цацрагийн долгионы урт нь 4мкм –80мкм–ийн завсарт харгалзана.Харин энэ муж дахь долгионы урттай цацрагуудаас хамгийн их энергитэй цацрагийн спектрт харгалзах долгионы урт нь 9мкм– 12мкм –ийн завсарт байдаг. Гэтэл нүүрсхүчлийн хийн молекулууд 13мкм – 17мкм,усны молекулууд 5мкм – 8мкм ба 14мкм –50мкм, озоны молекулууд 8.5мкм – 10.3мкм ба 13мкм –14.5мкм долгионы урттай цацрагуудын энергийг 40%– 99% шингээх чадвартай байгаа нь дунджаар 278K–289K температурт байгаа дэлхийн гадаргын дулааны цацрагуудаар зөөгдөж буй энергийн 70 орчим

* Electronic address: jdalkhsuren@yahoo.com

хувийг шингээж түүнийг дулааны энергид хувиргах боломжтой байна.

ОНОЛЫН ХЭСЭГ

Дэлхийн озоны давхаргыг бүрдүүлдэг O_3 -ын молекулууд Нарнаас ирж байгаа цацрагийн энергийн 12% буюу 168 Вт/м^2 цацрагийн эрчимийг шингээсний улмаас озоны давхарга $50-70^\circ\text{C}$ хүртэл температуртай болтлоо халдаг. Тэгвэл Дэлхийн гадаргаас 6м – 15м гүнд түүний абсолют температур дунджаар $278\text{K} - 289\text{K}$ байх тул тэндээс гарах дулааны цацрагийн эрчим дунджаар 328 Вт/м^2 байна. Энэ эрчимийн 70%-ийг шингээж авах замаар дулаанд хувиргаж чадвал 230Ж дулааны энергийг секунд тутамд 1м гадаргаас авна. Энэ энергийн 70%-ийг тогтоон барьж чадвал секунд тутамд дунджаар 160 Ж дулааны энергийг үйлдвэрлэх боломжтой байна. Энэ нь ийм хэмжээний энергийг шингээж байгаа хийн холимогийн температур $50^\circ\text{C} - 70^\circ\text{C}$ –д хүрэх боломжтой юм.

Абсолют тэг температураас ялгаатай температурт байгаа ямарч бодит биеийн цацрагийн эрчимийг Стефан –Больцманы хуулиар: $I = \delta \sigma T^4$ гэж тодорхойлно. Тухайн температурт байгаа биеээс гарч буй хамгийн их энергитэй цацрагийн спектрт харгалзах долгионы урт нь Винийн хуулиар:

$$\lambda_m = \frac{b_1}{T}$$

гэж тодорхойлогдоно. Энд b_1 – Винийн тогтмол $b_1 = 0.28978 \cdot 10^{-2} \text{ м} \cdot \text{К}$

Термодинамик тэнцвэрийн төлөвт байгаа абсолют хар биеийн гадаргын 1 м^2 талбайгаас 1с тутамд гарч байгаа цацрагийн энергийн спектр түгэлтийн график нь Планкын

$$B_\lambda d\lambda = \frac{2c^2 h}{\lambda^5} \frac{d\lambda}{e^{\frac{ch}{k\lambda T}} - 1}$$

хууль ёсоор зураг 1–д үзүүлсэн хэлбэртэй байна.




Зураг 1. 283 К температуртай биеийн дулааны цацрагийн энергийн эрчимийн $4 \text{ мкм} - 50 \text{ мкм}$ долгионы уртын завсар дахь түгэлт.

Графикаас харахад хамгийн их энергитэй цацрагийн спектрт цацрагийн харгалзах долгионы урт нь Винийн хууль ёсоор 10.2 мкм байна. Долгионы уртын 10.2 мкм -аас 4 мкм хүртэл интервалд цацрагийн энерги огцом буурч байна. Харин долгионы уртын 10.2 мкм -аас 30 мкм хүртэлх интервалд цацрагийн энерги аажмаар буурч байна. 1–р зургийн муруйгаар хязгаарлагдсан дүрсийн талбайн хэмжээ 283K температурт байгаа биеийн эрчимийн хэмжээтэй тэнцүү. Урт долгионт цацрагийн $4 \text{ мкм} - 50 \text{ мкм}$ долгионы уртын интервал дахь цацрагийн энергийг бүрэн шингээх чадвартай хийн атом молекулуудаар 283K температурт байгаа биеийн цацрагийн энергийг бүрэн шингээх замаар дулааны энерги үйлдвэрлэх юм. Эрдэмтэн судлаачид урт долгионт цацрагийн энергийг шингээх өндөр чадамжтай бодисууд буюу хийнүүдийг судалгаагаар тогтоож улмаар тэдний шингээлтийн хувь хэмжээг нь тодорхойлж чадсан байдаг. Тухайлбал, усны уурын молекулууд, нүүрсхүчлийн хийн молекулууд, озоны молекулууд урт долгионт цацрагийн энергийг спектрин тодорхой мужуудад сайн шингээдэг байна.

а. Усны уурын молекулуудын цацраг шингээлт, түүний онцлог

Агаар дахь усны уурын молекулууд нарны цацрагийн холын хэт ягаан туяа, үзэгдэх гэрлийн спектрин мужид сулавтар, ойрын хэт улаан цацрагийн спектрин мужид идэвхитэй, холын хэт улаан цацрагийн спектр мужид маш сайн шингээдэг **болох** нь олон судлаачдын удаан хугацааны судалгаагаар өндөр нарийвчлалтай тогтоогдсон байдаг.


Агаар дахь усны уурын цацраг шингээлт нь агаар дахь усны молекулын концентрациас болон цацрагийн долгионы уртаас ихээхэн хамаардаг болох нь Д.Макдональд, Ф.Фоуля нарын судалгаагаар маш нарийн тогтоосон байна. (1) 1 дүгээр зурагаас (Ч.Д.Уолшоу, ЭЛзассер нарын судалгаа) (2) хөрсний чийг цацрагийн ойрын хэт улаан, холын хэт улаан мужуудад өндөр шингээлттэй болох нь харагдаж байна.



Зураг 2. Усны молекулуудын холын хэт улаан цацрагийн муж дахь спектр шингээлт.

б. Нүүрс хүчлийн хийн (CO_2) цацраг шингээлт, түүний үр дагавар


Агаар мандалд өсөн нэмэгдэж буй нүүрс хүчлийн хий нь нарны цацрагийн холын хэт ягаан туяаны 100нм–200нм мужид шингээлттэй нь судлаачдын судалгаагаар нотлогдсон байна. Үүнээс гадна холын хэт улаан туяаны мужид хамгийн их энергитэй спектрийн 12,9мкм–17 мкм–ийн завсарт 15мкм–д төвтэй цацрагийн спектрыг маш сайн шингээдэг нь олон жилийн судалгаагаар батлагдсан байдаг. (1). 3 дугаар зураг. (В.Н.Кондратьев, А.В.Яковлев нарын судалгаа).



Зураг 3. Цацрагийн спектрийн 1мкм–20мкм завсарт нүүрс хүчлийн хийн цацраг шингээлт.

в. Озоны (O_3) цацраг шингээлт, түүний үр дагавар

Озон (O_3) нь ойрын хэт ягаан туяанаас гадна холын хэт улаан туяаг, ялангуяа өндөр энергитэй, 9мкм–10 мкм–ийн интервал дахь цацрагийг бараг 100% шингээдэг болох нь судалгаагаар тогтоогдсон. (3) Ийм учраас Озон дэлхийн гадаргаас болон агаар мандлаас цацаргаж буй холын хэт улаан цацрагийн хувьд хамгийн өндөр энергитэй, спектрийн 9мкм–10мкм завсар дахь цацрагийг бараг 100% шингээдэг онцлогтой.



Зураг 4. Озоны молекулуудын холын хэт улаан цацрагийн муж дахь спектр шингээлт.


ТООЦООЛОЛ, СУДАЛГААНЫ ХЭСЭГ

А. Цацрагийн энергийг шингээж авах арга технологи

Шингээх чадвар нь Онол, практикын хувьд батлагдсан хийнүүдийг ашиглан холын хэт улаан туяаны энергийг шингээж авна. Тодруулбал, 283К температуртай биеийн цацрагийн эрчим Стефана–Больцманы хуулиар: $I = \delta \sigma T^4 = 0.9 \cdot 5.67 \cdot 283^4 = 326.59 \text{ вт/м}^2$ байх тооцоо гарч байна. Үүний 70% – ийг нь дулааны энергид хувиргаж чадвал гадаргын 1 м^2 талбайгаас 1с тутамд 228.6 Ж дулааны энерги гаргаж авна. Винийн хуулиар 283К температурт байгаа биеийн хамгийн их энергитэй цацрагийн спектрт харгалзах долгионы урт нь 10.2 мкм байна. 10.2 мкм долгионы урттай цацрагийн энергийг озоны молекулууд 80% шингээх чадвартай. 283К температурт байгаа бие 5 мкм–100мкм хүртэл долгионы урттай цацрагийг гаргадаг бөгөөд энэ интервалд харгалзах энергийн ихэнх хувь нь 5 мкм–300мкм долгионы уртын завсарт ноогддог учраас энэ


завсарын энергийг шингээж авахад бидний гол зорилго оршино.

1. Озоны молекулуудын шингээлтийн спектрүүдийг 283К температурт байгаа биеийн цацрагийн спектрүүдтэй харгалзуулан /давхцуулан / үзэхэд озоны молекулууд 5 мкм – 300мкм долгионы уртын завсарт ноогдох энергийн 26.4% хувийг шингээх боломжтой болох нь дараах графикаас харагдаж байна. Зураг 4.




Зураг 4. 4мкм – 30мкм долгионы уртын завсарт озоны /O₃/ спектр шингээлт.

2. Нүүрсхүчлийн /CO₂/ хийн молекулуудын шингээлтийн спектрүүдийг 283К температурт байгаа биеийн цацрагийн спектрүүдтэй харгалзуулан /давхцуулан / үзэхэд 4мкм – 30мкм долгионы уртын завсарт ноогдох энергийн 17,6% хувийг нүүрсхүчлийн /CO₂/ хийн молекулууд шингээхээр байгаа нь дараах графикаас харагдаж байна. Зураг 5.



Зураг 5. 4мкм – 30мкм долгионы уртын завсарт нүүрсхүчлийн /CO₂/ хийн спектр шингээлт.

3. Усны уурын /H₂O/ молекулууд 4мкм – 30мкм долгионы уртын завсарт цацрагийн энергийн 29% хувийг өөртөө шингээж авах боломжтойг дараах графикаас харж болно. Зураг 6.



Зураг 6. Хэт улаан туяаны 4мкм – 30мкм долгионы уртын завсарт усны уурын /H₂O/- спектр шингээлт.

Шингээлтийн нийт хувь хэмжээ 26,4% /O₃/ + 17.6 / CO₂/ + 29% / H₂O/ = 73% байна. Энэ гурван хийн молекулууд 283К температуртай биеийн цацрагийн / 326.59вт/м² /эрчимийн 73%–ийг буюу 238.4вт/м² эрчимийг бүрэн шингээж улмаар цацрагийн энергийг дулааны энергид хувиргах боломжтой гэсэн тооцоо гарч байна.

Б. Шингээлтийн дүнд бий болсон дулааны энергийг алдагдал багатайгаар хадгалаж хуримтлуулах арга

Идэвхтэй хийнүүдийн үйлдвэрлэсэн /хувиргасан / дулааны энергийг цацрагийн болон дулаан дамжуулалтын хэлбэрээр гадагш алдах магадлал маш өндөр байдаг тул аль болох алдагдал багатайгаар ашиглах нь бидний гол зорилго билээ. Ийм учраас дулааны энергийн алдагдалыг бага байлгахын тулд толин ойлт болон вакуумжилтын арга технологийг ашиглана. Хий хадгалах савны дотор ханыг толиор доторлож гадна талыг дулаан муу дамжуулагч материалаар бүрж өгнө. Харин дулааны цацраг орох /нэвтрэх / зориулалттай хэсэг буюу савны ёроолыг вакуумжуулсан нимгэн шилэн хавтангаар хийнэ. Ийм технологиор савыг хийсэн тохиолдолд дулаан алдагдал 25–30%–иар буурна гэж тооцоолж байна. Дулаан алдагдалыг ийм хэмжээгээр бууруулахад дунджаар 168вт/м² эрчимтэй дулаан /дулааны энерги / үйлдвэрлэх боломжтой байна. Ийм эрчимтэй энергиэр цаг тутамд 1м² талбайтай гадаргаас 604.8 кЖ дулааныг үйлдвэрлэнэ. Энэ дулаанаар 10 °С температурт байгаа 3.6 л усыг нэг цагт 50°С температуртай болтол халаана.

ДҮГНЭЛТ

1. Озон, нүүрсхүчлийн CO_2 / хийн болон усны уурын молекулуудын спектр шингээлтийг ашиглан Дэлхийн нам температурын цацрагийн энергийн ойролцоогоор 73%–ийг дулааны энергид хувиргах боломжтой байна.
2. Шингээлтээр гаргаж авсан дулааны энергийн 70 орчим хувийг гадагш алдалгүйгээр хадгалаж, хуримтлуулж чадвал нэг цаг тутамд гадаргын 1м^2 тутмаас 604.8 кЖ дулааны энергийг гарган авч ахуйн хэрэглээндээ ашиглаж болохоор байна.
3. 8мкм –9мкм, 10мкм –14мкм долгионы уртын завсарт 90%–100% спектр шингээлттэй атом,молекулуудыг судалгаагаар олж тогтоож чадвал Дэлхийн нам температурын цацрагийн энергийг 100% дулааны энергид хувирган ашиглах боломж бүрдэхээр байна.

АШИГЛАСАН НОМ

- [1] К.Я.Кондратьев “Актинометрия”. г.Москва. Издательство “Мир” 1965год. стр 111,113, 235-236,296,312
- [2] А.Х.Харгиан “Физика атмосферы”. Г.Ленинград. Издательство “Наука” 1982года. стр 333, 411
- [3] С.П.Хромов, М.А.Петросянц. “Метеорология и климатология” г.Москва. Издательство “Наука” 1985 год.стр 129,258.
- [4] М.С.Эйгенсон “Солнце и Земля”.г.Москва. Издательство” наука” 1947 год.

Фемто секундын өдөөн судлах спектрометрийн аргыг хагас дамжуулагч материалууд дээр хэрэглэн судласан нь

Б.Өлзийбаяр^{1*}, П.Мөнхбаатар¹, Ц.Хос-Очир¹, Ц.Баатарчулуун², Г.Мөнхбаяр¹,
Н.Төвжаргал¹, М.Отгонбаатар¹, Г.Эрдэнэ-Очир¹, Ж.Даваасамбуу¹

¹Лазерын судалгааны лаборатори, Физикийн Тэнхим,

Шинжлэх Ухааны Сургууль, МУИС, Улаанбаатар 210646, Монгол Улс

² Геологи-Геофизикийн Тэнхим, Шинжлэх Ухааны Сургууль, МУИС, Улаанбаатар 210646, Монгол Улс

Хоёр ялгаатай өдөөн-судлах (ӨС) схемүүдийг өөр өөр фемтосекундын лазерын пульс ашиглан амжилттай хөгжүүлсэн. Хэт-богино пульс лазер ашигласан ӨС схемийг хэрэглэж, хөгжүүлсэн схемийн нарийвчлалыг тодорхойлох болон тохируулга хийх зорилгоор GaAs дахь когерент фононуудын өдөөлтийг хэмжсэн. Энэ когерент фонон давтамжууд нь бусад судлаачдын мэдээллэсэн утгуудтай [1, 2] сайн тохирч байсан. ZnSe болон GaAs-ийг харгалзан нэвтрэлт болон ойлтоор судалсан. ӨС туршилтын дохиог хэт-богино пульс лазер ашигласан үед баланслагч фото диодоор хэмжсэн болно. Өөр нэг ӨС туршилтын схемийн хувьд, ZnSe -ийн нэвтрэлтийн өөрчлөлтийг спектрээс нь хамааруулж хэмжих зорилгоор өмнөх ӨС схемд ашигласнаас өөр лазерын үүсгүүр ба бүртгэгч ашигласан. Спектрээс хамаарсан ӨС туршилтын схемд хүчтэй пульс лазер ашигласан хэмжилт мөн амжилттай болсон. Өргөн зурвастай, өндөр-нягтралтай спектрометрээр (HR4000CG-UV-NIR) бүртгэсэн болно.

PACS numbers: 78.47.J-, 78.66.Db

I. УДИРТГАЛ


1980аад оны эхэн үеэс хойш олон судалгааны багууд оптик пульс өдөөн-судлах аргыг ашиглан фемтосекундын хугацааны хэмжээтэй /нарийвчлалтай/ оптик пульсээр материал системийн хариу үйлчлэлийг судлаж байна[3, 4]. Эдгээр туршилтын хэд хэдэн тохиолдолд, Раман өдөөх процессоор үүсгэгдсэн хэлбэлзлүүд, хоёр фотоны шингээлт ажиглагдсан. Сүүлийн үед фемтосекундын өдөөн-судлах арга нь металл болон хэт дамжуулагчийн судалгаанд ашиглагдаж байна. Хагас дамжуулагч болон металл материалууд дээр хийсэн хэд хэдэн өдөөн-судлах туршилтанд, дээжийн оптик фонон моодуудтай тохирох давтамжуудтай хэлбэлзлүүд ойлтоор (эсвэл нимгэн дээжээр нэвтрэх нэвтрэлтээр) судлах үед ажиглагдаж байсан [5, 6]. Эдгээр хагас дамжуулагч дээжүүдийн хэлбэлзлүүдийг импульслэг албадмал Раман сарнилыг агуулсан шугаман бус оптик мэдрэх чадвараар тайлбарладаг [7]. Зарим хагас дамжуулагч дээжүүдэд оптик шинж чанарын огцом өөрчлөлт нь хоёр фотоны шингээлтийг агуулсан шугаман бус оптик мэдрэх чадвараар тайлбарладаг [8].

Энэ өгүүлэлт, бид хоёр ялгаатай өдөөн-судлах туршилтын аргын тохируулга хэмжилтийн үр дүнг үзүүлээ. 1-рт, хэт-богино пульс лазертай (6фс-ын үргэлжлэх хугацаатай) өдөөн-судлах туршилтанд ZnSe дахь эгшин зуурын нэвтрэлт, GaAs дахь когерент фононы хэлбэлзлийг хэмжсэн. 2-рт, хүчтэй пульс лазертай (пульсын энерги

нь 1 мЖ) спектрээс хамаарсан өдөөн-судлах туршилтыг ZnSe дээж дээр хийсэн. ZnSe болон GaAs -ийн хувьд өдөөн-судлах туршилтын үр дүн нь бусад судлаачдын үр дүнтэй сайн тохирсон[1, 10].

II. ТУРШИЛТ 1


Энэхүү ажлаар хэт-богино пульс лазерыг ашиглан өдөөн судлах туршилтын схемийн тохируулга хийсэн. Туршилтанд ашиглаж байгаа пульс лазерын төв долгионы урт нь 740нм (1.5эВ) байна. Пульсын үргэлжлэх хугацаа 6 фс. Лазерын давталтын хурд нь 75МГц байх үед пульсын энерги нь 4нж. Пульс лазерын спектрийг зураг 1 дээр тасархай шугамаар үзүүлэв.



Зураг 1: Пульс лазерын спектр (Rainbow 2)

Туршилтын схемийг зураг 2-т 2т үзүүлэв. Тусан пульсын 1-р цацраг хуваагч (ЦХ)-аар нэвтэрсэн хэсгийг өдөөгч пульс болгож ашигласан бөгөөд тусан пульсын ойтсон хэсэг нь 2-р цацраг хуваагчаар дахин хуваагдсан болно. 2-р цацраг ху-


*Electronic address: ulziibayarb@num.edu.mn



Зураг 2: Хэт-богино пульсын лазер (Rainbow 2) ашигласан нэвтрэлт хэлбэрийн өдөөн судлах туршлагын схем. BS - цацраг хуваагч, TS - шилжүүлэгч хавтан, M - толь, Scan delay - хэлбэлзэгч толь, PC - компьютер, PM - парабол толь, Sample - дээж, BPD - баланслагч фото диод

ваагчаар нэвтэрсэн пульс нь судлагч пульсээр, харин түүнээс ойсон пульс нь харьцуулах пульс болон ашиглагдсан. Гараар тохируулж болдог шилжүүлэгч хавтан дээр суурилсан хөдлөгч толь байх бөгөөд түүнээс ойсон өдөөгч пульс нь парабол толины тусламжтайгаар дээж рүү чиглүүлэгддэг. Харин хэлбэлзэгч толиноос ойсон судлагч пульс нь 2-р цацраг хуваагчаас дахин ойх бөгөөд дээж рүү хавтгай болон парабол толиор чиглүүлэгдэнэ. Өдөөгч ба судлагч пульсууд нь дээж дээр парабол толины тусламжтай фокуслагдана. Дээжээр нэвтэрсэн судлагч пульс нь баланслагч фото диод (БФД)-ийн нэг диод руу тусна. Харьцуулагч пульс нь хавтгай толины тусламжтай БФД-ийн нөгөө нэг диод руу тусна. БФД нь лазерын шуугианыг арилгах замаар судлагч болон харьцуулагч пульсуудын хоорондох эрчмийн маш бага ялгаврыг хэмждэг. ЦХ-аар нэвтрэн гарсан өдөөгч пульсыг хаалтаар халхалсан үед БФД дээр бүртгэгдэх дохио "0" байхаар тохируулсан. Ингэснээр өдөөгч пульсээр дээжийг өдөөх үед БФД нь зөвхөн түүгээр үүсгэгдсэн дохиог бүртгэнэ. Энэхүү өдөөгчөөр үүсгэгдсэн дохиог хэлбэлзэгч толь хөдөлж байх явцад хэмжиж авсан. Давтамж нь 1Гц, үр дүнг 100 удаагийн хэмжилтийн дунджаар тодорхойлж байгаа болно.

Туршилтын системийн тохируулга хийхээр ZnSe (хаалттай бүсийн өргөн 2.8 эВ) материал дээр нэвтрэлт хэлбэртэй өдөөн судлах туршилтыг гүйцэтгэсэн. Энэхүү дээж нь туссан пульс лазерын спектрийн мужид тунгалаг байдаг материал юм. Өдөөгч пульс, судлагч пульстай ойр




Зураг 3: ZnSe-ийн хувьд хугацаанаас хамаарсан нэвтрэлтийн өөрчлөлт ΔT

буюу давхцаж байх хугацаанд нэвтрэлтийн өөрчлөлт /зураг 3-т үзүүлсэн/ ажиглагдсан байна.

III. ТУРШИЛТ 2

Энэхүү ажлаар хэт-богино пульсын лазер (Rainbow 2) ашигласан ойлт хэлбэрийн өдөөн судлах туршлагын схемийг тохируулав. Уг схемийг зураг 4-т үзүүлсэн болно.


Туссан пульсын 1-р цацраг хуваагчаар нэвтэрсэн хэсгийг өдөөгч пульс болгож ашигласан бө-



Зураг 4: Хэт-богино пульсын лазер (Rainbow 2) ашигласан ойлт хэлбэрийн өдөөн судлах туршлагын схем. BS - цацраг хуваагч, TS - шилжүүлэгч хавтан, Sample – дээж, M - толь, Scan delay - хэлбэлзэгч толь, PM - парабол толь, BPD - баланслагч фото диод, PC - компьютер

гөөд туссан пульсын ойсон хэсэг нь 2-р цацраг хуваагчаар дахин хуваагдсан болно. 2-р цацраг хуваагчаар нэвтэрсэн пульс нь судлагч пульсээр, харин түүнээс ойсон пульс нь харьцуулах пульс болон ашиглагдсан. Гараар тохируулж болдог шилжүүлэгч хавтан дээр суурилсан байх хөдлөгч толинуудаас ойсон өдөөгч пульс нь парабол толины тусламжтайгаар дээж рүү чиглүүлэгддэг. Харин хэлбэлзэгч толиноос ойсон судлагч пульс нь 2-р цацраг хуваагчаас дахин ойх бөгөөд дээж рүү хавтгай болон парабол толиор чиглүүлэгдэнэ. Өдөөгч ба судлагч импульсууд нь дээж дээр парабол толины тусламжтай фокуслагдана. Дээжийн гадаргуугаас ойсон судлагч пульс нь хавтгай толиор чиглүүлэгдэн БФД руу тусна. Харьцуулагч пульс нь хавтгай толины тусламжтай БФД-ийн нөгөө нэг диод руу тусна. БФД нь лазерын шуугианыг арилгах замаар судлагч болон харьцуулагч импульсуудын хоорондох маш бага ялгаврыг хэмжих боломжтой байдаг. Мөн БФД нь судлагч болон харьцуулагч импульсуудын хоорондох эрчмийн ялгаврыг хэмжих боломжтой байдаг. Системийг өдөөгч пульс нь хаалтаар халхлагдсан үед БФД дээр бүртгэгдсэн дохио “0” байхаар тохируулсан байна. Ингэснээр өдөөгч импульсээр дээжийг өдөөх үед БФД нь зөвхөн түүгээр үүсгэгдсэн дохиог бүртгэнэ. Энэхүү өдөөгчөөр үүсгэгдсэн дохиог хэлбэлзэгч толь хөдөлж байх явцад хэмжиж авсан.

Туршилтын системийг тохируулахаар GaAs (хаалттай бүсийн өргөн 1.5 эВ) материал дээр ойлт хэлбэртэй өдөөн судлах туршилтыг гүйцэт-




Зураг 5: GaAs-ийн хугацаанаас хамаарсан ойлтын өөрчлөлт ΔR


гэсэн. Системийн үр дүн нь бага далайцтай когерент хэлбэлзлүүдийг харуулж байна. Давамгайлагч хэлбэлзэл нь 8.8 ТГц-ийн давтамжтай байсан бөгөөд энэ нь бусад туршилтын ажлын мэдээлэгдсэн утгуудтай сайн тохирч байна. Энэ нь зураг 4-т үзүүлсэн схем горимоороо зөв ажиллаж байгааг баталж байна.

IV. ТУРШИЛТ 3

ZnSe кристалл дээж дээр өдөөгч болон судлагч импульсуудын спектрийн нэвтрэлтийн өөрчлөлтийг янз бүрийн хугацааны хоцрогдолтой хэмжихийн тулд хүчтэй пульс лазер (Solstice Ace) ашигла-



Зураг 6: Хүчтэй пульс лазерн спектр (Solstice Ace)




Зураг 7: Хэт хурдан өсгөгч систем (Solstice Ace) ашиглан спектрээс хамаарсан өдөөн судлах туршилтын схем. BS - цацраг хуваагч, TS - шилжүүлэгч хавтан, M - толь, delay - моторт шилжүүлэгч хавтан, SM - спектрометр, PM - парабол толь, Sample - дээж, PC - компьютер

сан спектрээс хамаарсан өдөөн судлах туршилтыг хийсэн юм. Хэт хурдан өсгөгч систем (Solstice Ace) ашиглан спектрээс хамаарсан өдөөн судлах туршилтыг тохируулсан байгааг зураг 7-д үзүүлэв. Пульс лазерн төв долгионы урт нь 800нм (1.5эВ) байна. Пульсын үргэлжлэх хугацаа 120 фс (35-120фс-ийн хооронд гараар тохируулах боломжтой). Лазерын давталтын хурд нь 5кГц байх үед пульсын энерги нь 1.6мЖ буюу хүчтэй пульс энерги байна. Пульс лазерн спектрийг зураг 6 дээр үргэлжилсэн шугамаар үзүүлэв.

Энэ туршилтын ажлын хувьд туссан пульс нь цацраг хуваагчаар хуваагдана. ЦХ-аар нэвтэрсэн пульс нь өдөөгч пульс болон ашиглагдана. Энэхүү өдөөгч пульс нь компьютероос удирдагддаг, моторт шилжүүлэгч хавтан дээр суурилсан хөдлөгч толинууд руу тусах ба дээж рүү хавтгай болон парабол толиор чиглүүлэгдэнэ. ЦХ-аас ойсон пульс нь гараар тохируулдаг шилжүүлэгч хавтан дээр

суурилсан толинд ойх бөгөөд хоёр хавтгай болон парабол толиор дээж рүү чиглүүлэгдэнэ. Өдөөгч болон судлагч пульсууд нь дээж дээр фокуслагдана. Судлагч пульс нь дээжийн гадаргууд эгц тусах ба өдөөгч болон судлагч пульс хоорондох өнцөг нь ойролцоогоор 4° болно. Дээжээр нэвтэрсэн өдөөгч пульс нь хоёр дахь парабол толиноос ойсны дараагаар хаалтаар халхлагдана. Дээжээр нэвтэрсэн судлагч пульсыг цуглуулж спектрометр рүү илгээхийн тулд өөр нэг парабол толь ашигладаг. Өдөөгч пульстай харьцангуй судлагч пульсын хугацааны хоцрогдлыг өөрчлөхийн тулд шилжүүлэгч хавтан хөдлөж байх үед судлагч пульсын эрчмийг спектрометрээр хэмжсэн. Дээж (ZnSe)-ийн өдөөгчөөр өдөөгдсөн спектрийн нэвтрэлтийн өөрчлөлт нь зураг 8-д үзүүлсэн эрчмийн хэмжилтээс харагдана.



Зураг 8: Хэт хурдан өсгөгч систем (Solstice Ace) ашиглан спектрээс хамаарсан өдөөн судлах туршилтын схем. BS - цацраг хуваагч, TS - шилжүүлэгч хавтан, M - толь, delay - моторт шилжүүлэгч хавтан, SM - спектрометр, PM - парабол толь, Sample - дээж, PC - компьютер

ZnSe кристалл дээж дээр өдөөгч болон судлагч пульсуудын спектрийн нэвтрэлтийн өөрчлөлтийг янз бүрийн хугацааны хоцрогдолтой хэмжихийн тулд мөн л хүчтэй пульс лазер (Solstice Ace) ашигласан спектрээс хамаарсан өдөөн судлах туршилтыг хийсэн юм. Пульсын спектрийн мужид тунгалаг байдаг /нэвтрүүлэгч/ ZnSe кристалл нь өдөөгч пульс судлагч пульстай давхцах хугацаанд шингээгч шинж чанартай болж байсан. Иймд энэхүү дээж нь хоёр фотоны шингээлтийг судлахад таатай материал юм. ZnSe дээжийн хаалттай бүсийн өргөн (2.8эВ, [11]) нь пульс лазерн төв давтамжийн энергийн фотоноосойролцоогоор хоёр дахин их учраас энэ нь хоёр фотоны шингээлтийн процесс байж болно [10, 12] .

V. ДҮГНЭЛТ

Бид өдөөн-судлах туршилтын схемийг хүчтэй пульс лазер (Solstice Ace) болон хэт-богино пульс лазер (Rainbow 2)-ын оролцоотой хөгжүүлсэн болно. Эдгээр хөгжүүлсэн схемээ шалгах болон тохируулга хийх зорилгоор GaAs дахь когерент фононуудын өдөөлт ба өдөөгчөөр өдөөгдсөн нэвтрэлтийн өөрчлөлтийг хэмжсэн. Уг хөгжүүлсэн схемийг ашиглан хэмжсэн үр дүн маань энэ төрлийн бусад судалгааны ажлын мэдээлэгдсэн утгуудтай нийцэж байгаа явдал нь пульс лазерууд болон туршилтын схем маань цаашдын судалгаанд хэ-

рэглэх боломжтойг харуулж байна. Пульс лазерууд нь когерент хэлбэлзэл, дээд эрэмбийн шугаман бус эффект, аттосекундын пульс үүсгэх болон терагерцийн долгион үүсгэх зэрэг үзэгдлийг судлахад хэрэглэх боломжтой.

ТАЛАРХАЛ

Энэхүү судалгааны ажил нь ШУТС (Grants No. SSA 014/2016, SSA 017/2016), МУИС-ийн зочин судлаач төсөл (code P2017-2407)-ийн дэмжлэгтэйгээр хийгдэв.


-
- [1] G. C. Cho, W. Kutt and H. Kurz, Phys. Rev. Lett. **65**, 764 (1990).
 - [2] S. Adachi, J. Appl. Phys. **58**, R1 (1985).
 - [3] E. P. Ippen and C. V. Shank, Ultrashort Light Pulses, edited by S. L. Shapiro (Springer-Verlag, Berlin, 1984).
 - [4] C. B. Harris, E. P. Ippen, G. A. Mourou, and A. H. Zewail, Ultrafast Phenomena Springer-Verlag, Berlin (1990).
 - [5] H. J. Zeiger, J. Vidal, T. K. Cheng, E. P. Ippen, G. Dresselhaus, and M. S. Dresselhaus, Phys. Rev. **B 45**, 768 (1992).
 - [6] S. De Silvestri, J. G. Fujimoto, E. P. Ippen, E. B. Bamble, L. R. Williams, and K. A. Nelson, Chem. Phys. Lett. **116**, 146 (1985).
 - [7] M. J. Rosker, F. W. Wise, and C. L. Tang, Phys. Rev. Lett. **57**, 321 (1986).
 - [8] J. M. Chwalek, C. Uher, J. F. Whitaker, G. A. Mourou, and J. A. Agostinelli, Appl. Phys. Lett. **58**, 980 (1991).
 - [9] H. Kurz, QELS Digest 11, **58** (1991).
 - [10] J. Shen, Z. Zhang, and Z. Hua, Appl. Phys. Lett. **88**, 011113 (2006).
 - [11] D. J. Chadi, Phys. Rev. Lett. **72**, 534 (1994).
 - [12] X. Wan, X. Yao, M. Wang, and H. Hao, J. Electroceramics **21**, 737 (2008).

Физикийн лабораторийн хичээлийн “Физикийн хэмжилтийн асуулга” аргын тухай

С.Мөнхцэцэг*

Физикийн тэнхим, Байгалийн ухааны салбар, Шинжлэх ухааны сургууль, Монгол Улсын Их Сургууль

Их сургуулийн бакалаврын түвшний физикийн лабораторийн хичээлээс суралцагчийн олж авах мэдлэг нь хэмжилтийн үр дүнг тооцоолох, тайлагнах, хэмжилтийн үр дүнгийн алдаа буюу хазайлт эсвэл тодорхой бусын чанарыг ойлгох чадвар байна. Энэхүү чадварыг суралцагчийн хийсэн лабораторийн ажлын тайлангаас шалгаж үнэлнэ. Физикийн лабораторийн ажлын тайлангийн судалгаанд суурилсан үнэлгээний хэрэглэгдэхүүн болгож “Физикийн хэмжилтийн асуулга (ФХА)” (Physics Measurement Questionnaire (PMQ)) –ын аргыг боловсруулсаныг олон улсын их сургуулиуд (түүний дотор, Шведийн Уппсала их сургууль [1], АНУ-ийн Хойд Каролинагийн их сургууль [2], Мэриленд Коллеж Хүрээлэн [3, 4] болон Колорадо Бойлдерийн их сургууль [5], Өмнөд Африкийн Кэйп Тауны их сургууль [6-8] г.м.) амжилттай хэрэгжүүлжээ. Эдгээр сургуулиудад ФХА аргыг физикийн лабораторийн хичээлийн удиртгал хичээл болгон оруулснаар уламжлалт ба орчин үеийн сургалтын “либерал арт” системийн үнэлгээ болгон хэрэглэж байна.



ФХА аргын жишээг доор үзүүлэв. Өгөгдсөн нөхцөл: Дараах физикийн лабораторийн ажлыг оюутан гүйцэтгэжээ. Зурагт үзүүлсэн шиг налуу модон хавтанг ширээний өнцөгт хавчаараар тогтоожээ. h өндрөөс бөмбөгийг гулгуулахад бөмбөг хэвтээ чиглэлд налууг орхих ба ширээний өнцгөөс d зайд унав. Шалан дээр тусгай цаас дэвссэн бөгөөд бөмбөг унахдаа түүнд тэмдэг тавих юм.

Оюутны хийх даалгавар: h өндрийг өөрчлөхөд d зай хэрхэн өөрчлөгдөх вэ? h ба d –г метр ашиглан хэмжинэ үү.

Асуулт: Оюутан группээр хэмжилт хийнэ. Эхний даалгавар бол $h=400$ нм байхад d –г тодорхойлох. Нэг групп энэхүү даалгаварыг гүйцэтгээд d зайг 436 нм гэж хэмжив.

Оюутнуудын дунд дараах хэлэцүүлэг болов:

Та хэнтэй нь санал нэг байна вэ?

А	Б	В
---	---	---

Хариултаа тайлбарлана уу.



ФХА нь лабораторийн ажлын дата үр дүнд анализ хийх, үр дүнгээ дүрсжүүлэх, физик параметр хоорондын хамаарлаар үзүүлэх, компьютер тооцоо хийх болон үр дүнгийн тодорхой бус байдалд дүн шинжилгээ хийх чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн байна.

Хэмжилтийн үр дүнгийн тодорхой бус байдал нь бүхий л шинжлэх ухааны судалгаа шинжилгээний дотоод шинж чанарын асуудал юм. Шинжлэх ухаан нь өөрөө мэдлэгийг хөөн шинжлэх буюу ажиглалт ба туршлагаар дата цуглуулах, таамаг, гипотезийг хэлбэршүүлэх, амь оруулах, туршихад оршино.

Хэмжилтийн үр дүнгийн тодорхой бус байдалд хандах суралцагчийн хандлагаас харахад физикийн багшийн зүгээс “суралцагчдад

* Electronic address: munkhtsetsegs@gmail.com

хэмжилтийн үр дүнд анализ хийхэд хүндрэлтэй байдаг” гэсэн хэвшмэл ойлголтоос шалтгаалсан хүндрэл байдаг.

Дараах хэдэн ерөнхий характер суралцагчдад байдгийг ажиглалтаас харжээ:

- Суралцагч нь хэмжилтийн үр дүнд дүгнэлт өгөхдөө хэмжсэн хоёр утгын хоорондын тохирох эсэхэд эргэлздэг.
- Яагаад чухам хэмжилтийн энэ аргыг хэрэглэсэн болох ерөнхий ойлголтоо суралцагч ухаараагүй байна.
- Хэмжилтийн тодорхой үр дүнг тайландаа авдаг, харин үр дүндээ баталгаа хайдаггүй.
- Суралцагчийн хэмжилтийн тайландаа өгсөн дүгнэлт тодорхой хязгаартай байдаг. Жишээ нь, бид хэмжилтийн үр дүндээ компьютер ашиглан анализ хийсэн бөгөөд бидний хэмжилт алдаагүй байв. Эсвэл, хэмжилтийн алдаа нь гадны нөлөөний улмаас үүсэв. г.м.

Дээрх байдлаас гарахын тулд ФХА-г лабораторийн удиртгал хичээл болгон оруулж, физикийн лабораторийн хичээлийг судалгаанд суурилсан лаб хичээлийн түвшинд аваачих алхам хийх хэрэгтэйг тэмдэглэе.

НОМ ЗҮЙ

- [1] R. Lippmann Kung, C. Linder, NorDiNa 4, 40 (2006).
- [2] D. S. Abbot, Ph.D. thesis, North Carolina State University, (2003).
- [3] R. F. Lippmann, Ph.D. thesis, University of Maryland, College, Park (2003).
- [4] R. L. Kung, Am J Phys 73, 771 (2005).
- [5] H. J. Lewandowski, Robert Hobbs, Jacob T. Stanley, Dimitri R. Dounas-Frazer, Benjamin Pollard. Physics Education Research Conference 2017, Part of the PER Conference series. Cincinnati, OH: July 26-27, P. 244-247 (2017).
- [6] A. Buffler, F. Lubben, and B. Ibrahim, Int J Sci Educ 31, 1137 (2009).
- [7] A. Buffler, S. Allie, and F. Lubben, Int J Sci Educ 23, 37 (2001).
- [8] B. Campbell, F. Lubben, A. Buffler, and S. Allie, AJRMSTE, 1 (2005).

Барилгын материалын үйлдвэрлэлд ашиглагдаж буй цахилгаан станцын хаягдал үнсний цацрагийн судалгаа

С. Энхтуул*, Ж. Тэмүүжин

ШУА-ийн Хими, Химийн Технологийн Хүрээлэн

Нүүрсийг түлш болгон ашигладаг цахилгаан, дулааны болон дулааны цахилгаан станцуудын гаргаж буй үнс нь дэлхий дахинд хаягдаж буй 5 дахь том хаягдал түүхий эд гэж тооцогддог. Олон улсад үнсийг барилгын материал, бетоны нэмэлт, цеолит нийлэгжүүлэх, геополимерийн үйлдвэрлэл, шингээгч материал, керамикийн түүхий эд, хөрс бэхжүүлэгч, будгийн түүхий эд, дэвшилтэт шилэн керамик материал гарган авахад ашиглах боломжтойг дурдсан судалгаа ихээр хийгдэж байгаагаас зарим технологи нь үйлдвэрлэлийн түвшинд ашиглагдаж байна. Харин манай улсад цахилгаан станцын хаягдал үнсийг төдийлөн ихээр ашиглахгүй байсан нь нийгэмд уламжлал хэлбэрээр оршиж буй үнсэнд цацраг асар их хэмжээгээр агуулагдаж байдаг гэсэн туйлширсан ойлголттой холбоотой юм. Хэдийгээр нүүрсний үндсэн бүрэлдэхүүн хэсэг нь органик гаралтай боловч органик бус эрдэс болон бага агуулгатай мөр төдий (trace elements) хольцод байгалийн цацраг идэвхит элемент агуулагдаж болдог.

Цацраг идэвхит изотопууд нь альфа болон бета бөөмүүд болон гамма туяаг ялгаруулдаг. Альфа бөөм нь МэВ (MeV) хязгаарт хэмжигдэх өндөр энергитэй боловч масс ихтэйн улмаас нимгэн цаасыг ч нэвтрэх чадваргүй юм. Бета бөөмс нь хурдан электронууд бөгөөд тэдгээрийн энергийн хязгаар нь хэдэн зуун КэВ-оос хэдэн МэВ-д оршдог. Электронууд нь гелийн атомоос хөнгөн учраас альфа бөөмөөс илүү нэвтрэх чадвартай бөгөөд тэд агаарт бага зэргийн зайд нэвтрэн, нимгэн хуванцар юмуу маш хөнгөн металлыг нэвтрэн орох боломжтой. Гамма цацраг нь фотоны урсгал бөгөөд энерги нь ихэвчлэн хэдэн КэВ-оос хэдэн МэВ хүрдэг. Гамма цацраг нь хөнгөн цагааны нимгэн хальсыг нэвтэлж чадахгүй байж болох боловч бас энергийн хэмжээнээсээ хамааран хар тугалган хаалтыг ч нэлээн гүнзгий нэвтэрч болно. Үнсний

цацрагийн үзүүлэлтийн нэг нь инерт хий болох радон (Rn) юм. Гэсэн хэдий ч цахилгаан станцын нүүрсний шаталтын температур 1400-1500°C-д явагдаж аморф бүтэц бүхий бөмбөлөг үүсдэгээс радон хийний ялгарал харьцангуй бага байдаг нь судалгаагаар тогтоогдсон байна.

Бид энэхүү судалгаандаа Монгол улсын стандартын (MNS 6469 -2014) дагуу хаягдал үнсэн нэмэлттэй бетон бэлтгэхэд цацрагийн үзүүлэлт нь стандартад тавигдах шаардлагыг хангаж байгааг тодорхойлсон.

Цахилгаан станцын хаягдал үнсний цацрагийн үзүүлэлт тогтмол биш байдаг нь ашиглалтын явцад хүндрэл учруулах боловч дүүргэгч материалтай хольсны дараа стандартын шаардлагыг бүрэн хангаж байгааг 1-р хүснэгтэнд үзүүлэв.

1-р хүснэгт. Үнс болон үнсээр хийсэн геополимер тоосгоны цацрагийн үзүүлэлт.

№	Бүтээгдэхүүн	Изотопын идэвхи, Бк/кг			Радийн эквивалент (Ra _{экв}), Бк/кг
		A _{Ra-226}	A _{Th-232}	A _{K-40}	
1	Багануурын үнс (2011)	242.4	31.1	381.6	314.4
3	Багануурын үнс (2013)	1169.2	26.9	355.1	1233.6
6	Багануурын үнсэнд (2013) суурилсан бетон (үнс 20% + хайрга 80%)	119.2	13.1	697.9	195.7

Багануурын нүүрсний 2013 онд цуглуулсан үнсний цацрагийн үзүүлэлт өндөр байсан боловч бетоны дүүргэгч нэмсэний дараа стандартад тавигдах шаардлагыг хангаж байгаа нь Багануурын үнсийг цацраг идэвхит хаягдал бус харин бетонд хэрэглэгдэх үнэт түүхий эд гэж үзэж болохыг харуулж байна.

Түүнчлэн энэхүү судалгаанд цацрагийн агуулга өндөртэй үнсийг олон улсад хэрхэн

* Electronic address: ensurenjav@gmail.com

боловсруулж, ашиглаж байгааг тодорхой жишээнүүд дээр тоймлон харууллаа.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- [1] Бетонд хэрэглэх дулааны цахилгаан станцын шүүлтүүрийн үнс, Техникийн шаардлага, MNS 6469 -2014
- [2] Ж.Тэмүүжин, Нүүрсний үнсний шинж чанар, иж бүрэн боловсруулалт, хэрэглээ, 2017. Никель-Дикел, Монограф, 196 х
- [3] J.Temuujin, E.Surenjav, C.Ruescher, J.Vahlbruch, Processing and uses of fly ash addressing radioactivity (critical review), Chemosphere, 2018 (in press).

ГАРЧИГ

1.	Two-body problems in the orthogonal condition model M.Odsuren, G.Khuukhenkhuu, S.Davaa, K.Katō, A. Sarsembayeva	1
2.	Square-Root Differential Equations for Dark Matter Particles Namsrai. Kh, Munkhzaya. B	5
3.	Measurement of the $t\bar{t}\gamma\gamma$ production cross-section in pp collisions at a center-of-mass-energy of $\sqrt{s} = 13$ TeV with the ATLAS detector at the LHC Nomin-Erdene. E	12
4.	Влияние наноразмерного порошка диоксида кремния на физико-механические, прочностные характеристики лакокрасочного покрытия из эмали ХВ-16 В.Ц. Лыгденов, А.В. Номоев, С.П. Бардаханов, Т.В. Ларина	16
5.	Исследование бифуркаций периодических режимов при ламинарно-турбулентном переходе Т.Г. Дармаев	21
6.	Кварк ба антикваркийн холбоост төлөвийн тухайд Д.Дамбасүрэн	26
7.	Hydrogen atom ionization in femtosecond laser field: Numerical solution of the TDSE using CWFDVR method Ch.Aldarmaa, L.Khenmedekh, G.Zorigt	30
8.	Атомуудын өдөөгдсөн төлөвүүдийн энергийг Кон-Шэмийн тэгшитгэлээр тооцоолох нь Д.Наранчимэг, Л.Хэнмэдэх, Г.Мөнхсайхан, Н.Цогбадрах	34
9.	Вилсон урсгалын арга ашиглан тооцоолсон цэвэр гейж SU(3) урсгалын хоолойн зарим нэг үр дүнгүүд П.Баттогтох, Ч.Содбилэг, О.Качмарек, Г.Энхтуяа	37
10.	Жигд бус голомттой, цагираган өндөр температурын хийн хөргөлттэй реакторын нейтроник анализ Т.Жамъянсүрэн, С.Одмаа	44
11.	Геодезийн хэмжлийн нэгдмэл байдал нивелирийн рейкны хэвтээ компаратор Д.Өнөрбилэг, Б.Болормаа	51
12.	Графенаар хольцолсон катализатор гарган авах, түүний шинж чанарын судалгаа Б.Бумаа, Э.Уянга, Г.Сэвжидсүрэн, П.Алтанцог	56
13.	Metal-fullerene on materials for electronics E.M.Shpilevsky, P.Tuvshintur, S.A.Filatov, G.Shilagardi, D.Tumurbaatar, T.Otgonchimeg	61

14. Маш өндөр температурын хийн хөргүүртэй реакторын голомтын дизайны судалгаа Б.Хөхсүвд, С.Одмаа, Т.Жамъянсүрэн	66
15. Электрон бүтцийн тооцоололд Торын Больцманы загварыг ашиглах тооцооллын тойм Г.Мөнхсайхан, Б.Одонтуяа, Л.Хэнмэдэх, Д.Наранчимэг, До.Нямсүрэн	73
16. Физик сургалт ба загвар лаборатори, түүний ач холбогдол судалгаа П.Энхцэцэг, О.Лхагва, Т.Уламбаяр	78
17. Дэлхийн нам температурын цацрагийн энергийг дулаанд хувирган ашиглах боломж Ж.Далхсүрэн	82
18. Фемто секундын өдөөн судлах спектрометрийн аргыг хагас дамжуулагч материалууд дээр хэрэглэн судалсан нь Б.Өлзийбаяр, П.Мөнхбаатар, Ц.Хос-Очир, Ц.Баатарчулуун, Г.Мөнхбаяр, Н.Төвжаргал, М.Отгонбаатар, Г.Эрдэнэ-Очир, Ж.Даваасамбуу	87
19. Физикийн лабораторийн хичээлийн “Физикийн хэмжилтийн асуулга” аргын тухай С.Мөнхцэцэг	92
20. Барилгын материалын үйлдвэрлэлд ашиглагдаж буй цахилгаан станцын хаягдал үнсний цацрагийн судалгаа С.Энхтуул, Ж.Тэмүүжин	94